**НИЙСЛЭЛИЙН**
**ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 07 сарын 06 өдөр Дугаар 0/399 Улаанбаатар хот

Налайх дүүргийн Голомт цогцолбор сургуулийн
балансад бүртгэлтэй барилга байгууламж,
нийтийн эзэмшлийн хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 105 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын А/934 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчийн 2012 оны 07-11/96, 2015 оны 02-07-94/1070, 2018 оны 02-07-378/1003, 2019 оны 02-07-395/389, 02-07-093/84 дүгээр актуудаар ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон Налайх дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 1,421,660,527 /нэг тэрбум дөрвөн зуун хорин нэгэн сая зургаан зуун жаран мянга таван зуун хорин долоон/ төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан барилга байгууламж, нийтийн эзэмшлийн хөрөнгийг актлан, данс бүртгэлээсээ хасч, өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлт хийж ажиллахыг Налайх дүүргийн Голомт цогцолбор сургууль /Р.Цэдэндамбаа/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулахаар үнэлсэн 18,465,820 /арван найман сая дөрвөн зуун жаран таван мянган найман зуун хорин /төгрөгийн хөрөнгийг борлуулж, орлогыг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлж, акт болон бусад баримт бичгийн бүрдэлд хяналт тавьж ажиллахыг Захиргаа санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Рэнцэнбямбад даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ҮНЭНБАТ

11505000949

Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газрын
даргын 2020 оны 07 дугаар сарын 06...ний өдрийн
б/399... тушаалын хавсралт

## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ХӨРӨНГӨ

| № | Эд хөрөнгийн нэр | Ашигласан жил | Ашиглалтанд орсон он сар өдөр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Байгуулсан элэгдэл | Үлдэгдэл үнэ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Агуулахын 1-р барилга | 56 | 01/01/1963 | ш | 1 | 2,940,000 | 2,940,000 | 2,940,000.00 | - |
| 2 | Агуулахын 2-р барилга | 56 | 01/01/1963 | ш | 1 | 3,150,000 | 3,150,000 | 3,150,000.00 | - |
| 3 | Агуулахын 3-р барилга | 55 | 01/01/1964 | ш | 1 | 2,730,000 | 2,730,000 | 2,730,000.00 | - |
| 4 | Спорт заал | 53 | 01/01/1966 | ш | 1 | 326,975,670 | 326,975,670 | 259,975,249.09 | 67,000,421 |
| 5 | Спорт заалны дулааны шугам | 53 | 01/01/1966 | ш | 2 | 732,000 | 1,464,000 | 1,464,000.00 | - |
| 6 | Сдорт заалны цахилгааны шугам | 53 | 01/01/1966 | м | 88 | 18,409.09 | 1,620,000 | 1,620,000.00 | - |
| 7 | Цахилгааны шугам хичээлийн 1-р байр | 33 | 1/1/1987 | м | 87 | 27,000 | 2,349,000 | 2,349,000.00 | - |
| 8 | Цэвэр усны шугам хичээлийн 1-р байр | 59 | 1/1/1961 | м | 144 | 46,000 | 6,624,000 | 6,624,000.00 | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | Хичээлийн 1-р байр барилга | 59 | 1/1/1961 | ш | 1 | 990,558,852 | 990,558,852 | 960,714,818.92 | 29,844,033.08 |
| 10 | Бохирын шугам хичээлийн 1-р байр | 59 | 1/1/1961 | м | 36 | 229,139 | 8,249,000 | 8,249,000.00 | - |
| 11 | Дулааны шугам хичээлийн 1-р байр | 59 | 1/1/1961 | м | 78 | 698,958 | 54,518,750 | 54,518,750.00 | - |
| 12 | Дулааны дотор шугам хичээлийн 1-р байр | 4 | 23/02/2016 | м | 1 | 10,762,855.00 | 10,762,855 | 762,368.90 | 10,000,486.10 |
| 13 | Явган зам | 38 | 1/1/1982 | м | 197 | 19,000.00 | 3,743,000 | 3,743,000.00 | - |
| 14 | Мод | 12 | 25/01/2008 | ш | 45 | 80,000.00 | 3,600,000 | 3,600,000.00 | - |
| 15 | Асфальтан талбай | 12 | 25/01/2008 | м | 200 | 500.00 | 100,000 | 100,000.00 | - |
| 16 | Зүлэг | 12 | 25/01/2008 | м | 1027 | 200.00 | 205,400 | 205,400.00 | - |
| 17 | Хайс төмөр шинэ | 12 | 25/01/2008 | ш | 60 | 6,500.00 | 390,000 | 390,000.00 | - |
| 18 | Хайс төмөр | 2 | 23/04/2018 | ш | 140 | 12,000.00 | 1,680,000 | 437,500.00 | 1,242,500.00 |
| ***Нийт данснаас хасах хөрөнгийн дүн*** | | | | | | | ***1,421,660,527.00*** | ***1,313,573,086.91*** | ***108,087,440.09*** |